



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/269

Мөрөн

Санхүүжилт олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.13, 58.2.17, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2013 оны 178 дугаар зарлиг, аймгийн ИТХ-ын ээлжит 2014 оны Х хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Экологийн ул мөрийг бууруулах төслийг 1 000 000 төгрөг, телевизийн захиалгат нэвтрүүлэг 200 000 төгрөг, бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зохион байгуулах, хууль бус мод бэлтгэхтэй тэмцэх ажилд шаардлагатай 750 000 төгрөгийн санхүүжилтийг баталсугай.

2. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 1 950 000 /Нэг сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг тухай бүр байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээний зардлаас гарган санхүүжүүлэхийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Р.Жаргалсайхан/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР